

3.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахад ажил олгогчийн үүрэг хариуцлагыг дээшлүүлж, ажилтнууд аюул эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах зөв хандлагыг төлөвшүүлэх 2 дугаар зорилтын хүрээнд:

3.2.1. Ажлын байр, үйлдвэрлэлийн орчинд гарч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, дохио, санамж, анхааруулга, тэмдэг тэмдэглэгээ тавьж, хаалт хамгаалалтыг бүрэн хийж хэвшихэд ажил олгогч бүр санаачилгатай хандаж, аюулгүй орчинг бүрдүүлэх.

3.2.2. Аж ахуйн нэгж, байгууллага бүр ажилтнуудыг шаардлага хангасан ахуйн байраар хангах, алжаал /стресс, сэтгэлийн хямрал/ тайлах, чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөн хийх өрөө танхимтай болох хөдөлгөөн өрнүүлэх.

3.2.3. Аж ахуйн нэгж, байгууллага хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн алба, ажилтныг орон тоо, бүтцээр ажиллуулах, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг байгуулж, гишүүдийг дадлагажуулах, чадавхжуулах ажлыг зохион байгуулах.

3.2.4. Ажил олгогч ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах зэрэг асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжүүлж байх.

3.2.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг ажилтан бүрт ойлгомжтой, энгийн, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйншилдэг арга барил, туршлагаа бусдад үзүүлэх сургалт хэлбэрээр түгээх ажлыг зохион байгуулах.

Хүрэх үр дүн: Аж ахуйн нэгж, байгууллагууд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн заалтыг мөрдөн хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа өөрчлөлт гаргаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүтэц, орон тоог бий болгосноор ажил олгогчийн үүрэг хариуцлага дээшилж, ажилтнуудын аюулгүй ажиллагааны соёл, зөв хандлага төлөвшсөн байна.

3.1. Ажил олгогч бүр ажилтныг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, ажлын байран дахь эрсдлийн үнэлгээг хийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, үйлдвэрлэлийн ослын тоог бууруулах 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, хяналтын үр нөлөөтэй арга хэлбэрийг төлөвшүүлэх 4 дүгээр зорилтын хүрээнд:

3.1.2. Аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлж, чиглэл, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.

3.1.3. Дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэстэй болон бусад түншлэгч байгууллагатай хамтран хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт шалгалтыг зохион байгуулж, зөвлөн туслах үйл ажиллагаа явуулах.

3.1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийг дүүргийн Засаг даргын болон салбар хариуцсан Засаг даргын төсвийн багцад тусган хэрэгжүүлэх.

3.1.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон нутгийн болон аж ахуйн нэгж, байгууллагын ажилтныг чадавхижуулах сургалт арга хэмжээг зохион байгуулах.